

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Энх-Үйлс өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2024/14/НА-СТА-ТЗШ

Цахим хуудас:
www.audit.mn

Мөрөн сум
2024 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас:88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 88095436 Цахим хаяг: Davaanyamb@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88688168 Цахим хаяг: Ichinkhorloog@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.23 № 01/61
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЭНХ-ҮЙЛС
ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Н.ХОРОЛМАА ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Энх-Үйлс өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Энх-Үйлс өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Үндсэн хөрөнгө болон засгийн газрын хувь оролцоо данс өмнөх оноос 4 дахин өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 667,436.4 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй өрхийн эрүүл мэндийн төвийн шинэ барилгыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 81 дугаар тогтоолыг үндэслэн данс бүртгэлд тусгасантай холбоотой байна.

Аудитын гол асуудал

Хөвсгөл аймгийн эрүүл мэндийн газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/77 дугаар тушаалаар үнэ төлбөргүй хуваарилагдан ирсэн эм, эмнэлгийн хэрэгслээс түүвэрлэн тоолоход 2023 оны 5 болон 10 дугаар сард хугацаа дууссан бүтээгдэхүүнүүд байна. Уг хугацаа дууссан бүтээгдэхүүнүүдийг ангилж ялгасан тэмдэглэгээгүй, хугацаа дууссан гэдгийг эмнэлгийн алба хаагчид мэдээгүй, шууд хэрэглэхэд бэлэн байдалтай байгаа нь нийтийн эрүүл мэндэд эрсдэл учирч болзошгүй нөхцөл байдал гэж үзээд журмын дагуу шийдвэрлэх талаар зөвлөмж хүргүүлж, дараагийн аудитаар анхаарах хэсэгт тусгалаа.

Бусад асуудлын хэсэг

Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т "Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн үзүүлэх Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1-д заасан

6724040085

тусламж, үйлчилгээний зардлыг тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар тооцож, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.” Гэж заасны дагуу эрүүл мэндийн даатгалын сангаас 100 хувь санхүүжиж байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	44,882,042.25	67,683,381.61
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	22,615.51	24,673.81
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	22,615.51	24,673.81
3121	Төгрөг	22,615.51	24,673.81
31211	Төрийн сангийн харилцах	22,615.51	24,673.81
33	АВЛАГА	00.00	23,572,266.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	234,000.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	23,338,266.00
35	БАРАА МАТЕРИАЛ	44,859,426.74	44,086,441.80
351	Түүхий эд материал	33,042,044.10	32,064,106.16
35110	Тусгай зориулалттай материал	12,715,502.63	17,615,983.66
35130	Эм боох материал	20,326,541.47	14,448,122.50
354	Хангамжийн материал	11,817,382.64	12,022,335.64
35470	Бусад хангамжийн материал	11,817,382.64	12,022,335.64
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	144,515,524.33	797,591,078.01
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	144,515,524.33	797,591,078.01
392	Биет хөрөнгө	127,635,024.33	780,710,578.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	65,116,270.84	732,552,737.84
39202	Хуримтлагдсан элэгдэл	-11,138,089.92	-23,651,997.39
39203	Авто-тээврийн хэрэгсэл	12,750,000.00	12,750,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-3,585,937.50	-5,179,687.50
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	71,782,078.00	81,742,057.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-14,483,641.73	-24,320,161.79
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	9,060,047.82	9,655,047.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	-2,391,463.88	-3,248,892.95
39214	Бусад үндсэн хөрөнгө	811,475.00	811,475.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-285,714.30	-400,000.02
393	Биет бус хөрөнгө	16,880,500.00	16,880,500.00
39301	Програм хангамж	287,500.00	287,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	16,593,000.00	16,593,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	189,397,566.58	865,274,459.62
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	189,397,566.58	865,274,459.62
51	Засгийн газрын хувь оролцоо	189,397,566.58	865,274,459.62
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	51,617,264.23	719,053,731.23
51101	Өмч: - төрийн	51,617,264.23	719,053,731.23
512	Хуримтлагдсан үр дүн	103,584,015.71	112,024,441.75
51210	Өмнөх үеийн үр дүн	103,584,015.71	103,584,015.71
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	8,440,426.04
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	34,196,286.64	34,196,286.64
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	189,397,566.58	865,274,459.62

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	407,242,819.37	432,097,330.85
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	87,780,119.37	39,041,382.71
120	Нийтлэг татварын бус орлого	86,665,119.37	39,041,382.71
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	82,724,359.37	37,515,082.71
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	82,724,359.37	37,515,082.71
120009	Бусад орлого	3,940,760.00	1,526,300.00

122	Тусламжийн орлого	1,115,000.00	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	1,115,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	319,462,700.00	393,055,948.14
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	319,462,700.00	393,055,948.14
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	319,462,700.00	393,055,948.14
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	428,776,764.34	423,656,904.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	428,776,764.34	423,656,904.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	391,274,214.34	414,493,504.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	232,339,141.00	258,058,186.00
210101	Үндсэн цалин	232,339,141.00	258,058,186.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,263,555.22	31,981,629.55
210202	Тэтгэмжийн даатгал	28,263,555.22	31,981,629.55
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,845,568.70	10,984,675.79
210301	Гэрэл, цахилгаан	1,360,753.70	2,068,290.29
210302	Түлш, халаалт	4,484,815.00	7,318,575.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	1,597,810.50
2104	Хангамж, бараа материалын зардал	12,174,134.00	15,332,749.00
210401	Бичиг хэрэг	3,891,810.00	4,260,582.00
210402	Тээвэр, шатахуун	2,600,000.00	3,688,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,420,370.00	1,435,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	329,500.00	1,300,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,871,100.00	1,441,547.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,061,354.00	3,206,720.00
2105	Нормативт зардал	93,662,821.90	59,092,113.15
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	93,662,821.90	57,022,113.15
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	2,070,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	171,600.00	1,719,261.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	48,000.00	1,550,261.00
210604	Урсгал засвар	123,600.00	169,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,172,000.00	2,084,400.00
210702	Дотоод албан томилолт	1,172,000.00	2,084,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	580,292.00	1,361,281.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	1,080,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	49,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	33,936.00	33,936.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	00.00
210807	Газрын төлбөр	55,256.00	67,845.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	119,100.00	130,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,065,101.52	33,879,209.32
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,586,573.00	6,938,390.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,039,120.00	2,024,927.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	12,439,408.52	24,915,892.32
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,502,550.00	9,163,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,502,550.00	9,163,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	37,502,550.00	9,163,400.00

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-21,533,944.97</u>	<u>8,440,426.04</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-21,533,944.97</u>	<u>8,440,426.04</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	365,480,306.00	371,243,982.14
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,940,760.00	1,526,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,940,760.00	1,526,300.00
120009	Бусад орлого	3,940,760.00	1,526,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	361,539,546.00	369,717,682.14
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	361,539,546.00	369,717,682.14
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	571,662.00	00.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	360,967,884.00	369,717,682.14
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	360,032,308.92	367,946,923.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	360,032,308.92	367,946,923.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	321,958,096.92	358,783,523.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	232,339,141.00	258,292,186.00
210101	Үндсэн цалин	232,339,141.00	258,292,186.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,263,555.22	31,981,629.55
210202	Тэтгэмжийн даатгал	28,263,555.22	31,981,629.55
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,845,568.70	10,984,675.79
210301	Гэрэл, цахилгаан	1,360,753.70	2,068,290.29
210302	Түлш, халаалт	4,484,815.00	7,318,575.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	1,597,810.50
2104	Хангамж, бараа материалын зардал	15,186,884.00	15,489,702.00
210401	Бичиг хэрэг	3,891,810.00	4,260,582.00
210402	Тээвэр, шатахуун	2,600,000.00	3,508,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,420,370.00	1,435,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	329,500.00	1,300,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,883,850.00	1,778,500.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,061,354.00	3,206,720.00
2105	Нормативт зардал	27,509,363.00	28,674,732.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	26,959,363.00	26,736,732.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	550,000.00	1,938,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,935,600.00	1,021,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,812,000.00	852,600.00
210604	Урсгал засвар	123,600.00	169,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,172,000.00	2,084,400.00
210702	Дотоод албан томилолт	1,172,000.00	2,084,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	580,292.00	1,361,281.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	1,080,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	49,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	33,936.00	33,936.00

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	00.00
210807	Газрын төлбөр	55,256.00	67,845.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	119,100.00	130,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,125,693.00	8,893,317.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,086,573.00	6,868,390.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,039,120.00	2,024,927.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,074,212.00	9,163,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,074,212.00	9,163,400.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	571,662.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	37,502,550.00	9,163,400.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>5,447,997.08</u>	<u>3,297,058.30</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>5,450,000.00</u>	<u>3,295,000.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>5,450,000.00</u>	<u>3,295,000.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	<u>5,450,000.00</u>	<u>3,295,000.00</u>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,450,000.00	3,295,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-5,450,000.00</u>	<u>-3,295,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-2,002.92	2,058.30
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	24,618.43	22,615.51
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	22,615.51	24,673.81

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	39,023,264.23	22,858,965.00	10,782,732.16	00.00	72,664,961.39
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	39,023,264.23	22,858,965.00	10,782,732.16	00.00	72,664,961.39
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	164,257.86	00.00	164,257.86
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	51,617,264.23	34,196,286.64	103,584,015.71	00.00	189,397,566.58
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	51,617,264.23	34,196,286.64	103,584,015.71	00.00	189,397,566.58
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	51,617,264.23	34,196,286.64	103,584,015.71	00.00	189,397,566.58
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	667,436,467.00	00.00	00.00	00.00	667,436,467.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	8,440,426.04	00.00	8,440,426.04
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	719,053,731.23	34,196,286.64	112,024,441.75	00.00	865,274,459.62

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 234.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 234.0 мянган төгрөгийн алдааг залруулж, дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа: Томилолтоор явсан албан хаагчдын цалин хөлсийг тооцохдоо хоолны нэмэгдлийг давхардуулан олгосон байна. Энэ нь Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 52,587.4 мянган төгрөгийн 5 зөрчил² илэрснээс 52,587.4 мянган төгрөгийн 5 зөвлөмжийг Хөвсгөл аймгийн Энх-Үйлс өрхийн эрүүл мэндийн төвийн дарга, нягтлан бодогч нарт хүргүүлсэн. Дээрх зөрчил нь материаллаг бус зөрчил байна.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Дотоод хяналтын багийн 2023 оны ажлын тайлантай танилцахад төлөвлөсөн ажлын гүйцэтгэл дутуу, илэрсэн зөрчил арилгуулах, цаашид сайжруулах талаар зөвлөмж хүргүүлж, ажил сайжруулах талаар үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн эгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 3 дугаар зүйлийн 3.7.6-д “хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх” гэж заасанд нийцээгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ илэрсэн зөрчлийг арилгуулах, байгууллагын хэвийн үйл ажиллагаа болон санхүү бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах талаар хэрэгжих боломжтой зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг тооцож, тайлагнаж, үр дүнг хамт олны хурлаар хэлэлцүүлж ажиллах.

Илрүүлэлт: Өндөр үлдэгдэлтэй эм, эмнэлгийн хэрэгсэлд биет тооллого хийхэд хадгалах хугацаа дууссан ковидын оношлуур, нүдний шил, нэг удаагийн хувцас /комбинзон/, маск зэрэг Эрүүл мэндийн газраас 2023 оны 11 дүгээр сард үнэ төлбөргүй хуваарилсан хэрэгслүүд байна. Хугацаа дууссан эм, хэрэгслийг тусгаарлаж, ялгаж тэмдэглэсэн тэмдэглэгээ, сав баглаа боодолгүй, агуулахад хадгалаатай байна. Мөн хугацаа дууссан дох тэмбүүний тест 36 хайрцаг бодит үлдэгдэлтэй байхад нягтлан бодох бүртгэлд үлдэгдэлгүй зөрчилттэй байна. Энэ нь Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Үйл ажиллагаандаа чанарын стандартын шаардлагыг хангах” гэж заасныг зөрчсөн, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Агуулахад хадгалаатай байгаа эм, эмнэлгийн хэрэгсэлд хяналт хэрэгжүүлэх ажлын хэсэг томилж, хугацаа дууссан бүтээгдэхүүнийг олж тогтоон нэр төрөл, үнэ, хэзээ хаанаас авсан зэрэг мэдээлэл бүхий жагсаалт үйлдэж, Эрүүл мэндийн сайдын 2011 оны 158 дугаар тушаалаар баталсан “Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, халдваргүйтгэх, устгах заавар”-ын дагуу хугацаа дууссан тэмдэг тэмдэглэгээ хийж тусгаарлан, устгалыг журмын дагуу шийдвэрлэх.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт: Тус төв нь 2023 оноос шинэ байранд үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд 51,475.8 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй хуучин газар, хашаа байшин нь одоогоор ашиглалтгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ашиглалтгүй байгаа газар, хашаа байшинг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлэх.

2. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагад мөрдлөг болгон ажиллаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн хэлбэрт шилжсэн болон боловсролын салбарын хууль эрх зүйн шинэчлэлд нийцүүлэн шинэчлэн боловсруулж ажиллаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасанд нийцээгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, стандартад орсон өөрчлөлтөд нийцүүлэн шинэчлэн боловсруулах.

3. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Энх-Үйлс өрхийн эрүүл мэндийн төв нь Шилэн дансны тухай хуульд заасны дагуу 2023 оноос эхлэн улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн талаарх мэдээллийг улирал бүр мэдээлэх үүрэгтэй боловч тайлант оны санхүүжилтийг огт мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9-д “Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын болон орон нутгийн тусгай зориулалтын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, Засгийн газар, түүний харьяа байгууллагаас гаргасан бонд, үнэт цаас, өрийн бичиг, баталгаа, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр хөрөнгө оруулалт, санхүүжилтээ хүлээн авсан төсвийн байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байрлуулах ба шаардлагатай гэж үзвэл олон нийтийн бусад цахим хуудас, өөрийн цахим хуудсаар давхар мэдээлж болно” гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9-д заасан мэдээллийг улирал бүр, үнэн зөв, иж бүрэн мэдээлж хэвших

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Томиллолт, хоол, унааны мөнгө давхардуулан олгосон	1	234.0			1	234.0						
Дүн	1	234.0			1	234.0						

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дотоод хяналт хариуцлагатай холбоотой	1	0					1	0
НБББББ-тэй холбоотой	1	0					1	0
Хугацаа дууссан эм эмнэлгийн хэрэгсэлд холбогдох арга хэмжээг аваагүй	1	1,111.6					1	1,111.6
Ашиглалтгүй үндсэн хөрөнгөтэй холбоотой	1	51,475.8					1	51,475.8
Дүн	4	52,587.4					4	52,587.4

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны мэдээлэл огт оруулаагүй.	1	0					1	0
Дүн	1	0					1	0